

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”
Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234734

“МОНГОЛЫН БУРХАНЫ ШАШНЫ АМАН ТҮҮХ” ХЭМЭЭХ
ГУРВАН ЦУВРАЛЫН ТУХАЙ

Д.Даваасүрэн

Хураангуй. Бурханы шашин, Монголд дэлгэрсэн Бурханы шашныг манай үе үеийн эрдэмтэд бүхий л мэдлэг ухааны үүднээс анхааран судалсаар ирсэн арвин баялаг уламжлалтай. Энэ уламжлал өнгөрсөн зууны эхэн үеэс үзэл сурталын нөлөөгөөр хоригдсон хэдий ч, Ц.Дамдинсүрэн, Б.Ренчин, Ш.Бира тэргүүтэй билигт өтгөс утга зохиол, хэл шинжлэл, гүн ухаан зэрэг шинжлэх ухааны хальс бүрхэвч дор оруулан, анхааран судалсаар ирсэн билээ. Гэсэн хэдий ч, XX зууныг шашингүйн үзэл суртал ноёрхсон, иргэний шүтэх, эс шүтэх эрхийг хязгаарласан зэрэг тодорхой хүчин зүйлийн улмаас олон нийт социализмын үеийн Монголд Бурханы шашныг Улаанбаатар хот дахь Гандан хийдээр төсөөлж, хэмжиж ирсэн нь Монголын өргөн уудам нутагт шашин шүтлэгтээ үнэнч байж, уламжлалт өв соёлоо хадгалж өнөө цагт золгуулсан өвгөдийн ач гавьяаны талаар өнөө хэр дорвитой авч үзэж, үнэлж дүгнээгүй байсаар байхад хүргэжээ. Иймд, нэгэн түүхэн цаг үеийн Монголын Бурханы шашин, иргэний шүтэх, эс шүтэх эрхийн нөхцөл байдлыг тодруулахад “Монголын Бурханы шашны аман түүх” хэмээх 3 цуврал нь үнэ цэнтэй бүтээл болсон байна.

Уг цувралд ганцаарчилсан ярилцлагын хэлбэрийг ашиглан, оролцогчидтой ярилцаж, тэдний өгсөн яриаг боловсруулсан нь судалгааны өргөн хүрээний ач холбогдолтой хэдий ч, бас ташаа мэдээ мэдээлэл байгаа нь түүхэн үнэнийг баримтжуулах талаасаа явцын болон эцсийн үр дүнд хүрэх шатандаа судлаачид анхаарах, бүх л боломжоор залруулах шаардлагаар энэхүү өгүүллийг бичив.

Үндсэн зүйл

Унгар улсын Өтвөш Лорандын нэрэмжит эрдэм шинжилгээний Их сургуулийн судлаач Майер Жужа, Телеки Кристина нарын хамтын бүтээл **“Өндөр настан лам нарын яриа (XX зууны эхэн үеийн хүрээ хийдүүдийн тухай ярилцлагууд) 2006-2009”**, Телеки Кристина-гийн **“Өндөр настан лам нарын яриа (XX зууны эхэн үеийн хүрээ хийдүүдийн тухай ярилцлагууд) 2007-2017”**, Чимэдциеэгийн Хулан, Сю Бөрн нарын эмхэтгэсэн **“Дурсамжид үлдсэн сүм хийдүүд” (XX зууны эхэн үеийн хүрээ хийдүүдийн тухай ярилцлагууд)** буюу “Монголын Бурханы шашны аман түүх” хэмээх ерөнхий нэрийн доор багтах 3 цуврал 2023 онд хэвлэгджээ.

“Цуврал I”-д **“2006-2009 он хүртэл уулзсан 40 ламын 40 орчим хийдийн тухай ярьсан 80 орчим яриа орсон”** (Телеки Кристина, 2023:5) бол, “Цуврал II”-т **“2007-2017 оны хооронд уулзсан 34 ламын 35 орчим хийдийн тухай ярьсан нийт 47 яриа орсон”** (Майер Жужа ба Телеки Кристина, 2023:5) байна. Харин “Цуврал

III” нь “Монголын сүм хийдийн түүхэн товчоо” төслийн үр дүнгээр, Сю Бөрний санаачилгаар уг цувралд оруулан хэвлүүлсэн бөгөөд “1939 оноос өмнө сүм хийдэд шавилан сууж байсан 142 өвгөн лам нарын дурсамж, 183 сүм хийдтэй холбогдох аман түүх” (Хулан Ч., Сю Бөрн, 2023:14) багтжээ.

Дээрх гурван цувралд, Өвөрхангай аймгийн Хархорин сумын Шанх багийн нутагт буй Баруун хүрээний талаар хожмын Ламрим дацангийн ловон Хишигтийн Гомбо, тус хүрээний Шаддүвлин аймгийн шавь гэлэн Жанцаны Довдон, гэлэн Нямын Осор, лам Норжмаагийн Дашцэрэн нарын өгсөн ярилцлага багтсан байна.

Юуны өмнө, эл гурван цуврал нь социализмын үеийн Монгол дахь Бурханы шашны нөхцөл байдлын судалгаанд үнэ цэнтэй бүтээл мөнийг тэмдэглэж байна. 1937 он гэхэд Бурханы шашин Монголд нэгэнт үгүй болж, 1944 онд Гандан дуган нэрээр сэргэн бараг нь музейн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байсан ор нэрийн төдий нэгнийг 1990 онд “морь унаж, мод тохож” ирсэн холын хүмүүс сэргээв гэх шиг шахуу ойлгогдох болсон Монголын Бурханы шашны түүхэн үнэн байдлыг нэхэн судлахад ямар нэг байдлаар дэмтэй, хэрэгтэй ном болжээ хэмээн олзуурхаж байна. Ер нь Гандантэгчэнлин хийдийн цорж асан Г.Диваасамбуугийн “Гандантэгчэнлин хийд дахин сэргээсэн түүх” (2009) зэрэг номыг эс дурдвал, социализмын үеийн Монгол дахь Бурханы шашны нөхцөл байдлын судалгаанд шууд авч хэрэглэж болох судалгааны эх хэрэглэгдэхүүн ховор хомс байсаар байна.

Энэхүү өгүүллийг дээрх “Монголын Бурханы шашны аман түүх” хэмээх ерөнхий нэрийн доор багтах гурван цувралд буй Баруун хүрээнд холбогдох мэдээ мэдээлэлд холбогдуулан бичиж байна. Ер нь тус хүрээнд шууд хамаарах төвөд, тэдгээрийн орчуулга болон тэдгээрт тулгуурлан бичсэн кирилл үсгээр буй дараах номууд байна. Үүнд:

1. Агваанцүлтэмжамц, (Номгоны сүмийн Дара эх ламтан). skyabs-mgon rje-btsun dam-pa'i gdan-sa sgar-chen gyas-ma'i 'byung-tshul mdo tsam-du brjod-pa gzur-gnas rna-ba'i bjud-len ces-bya-ba bzhugs-so. [төвөд, гар бичмэл, 39.4x9. 27 хуудас]

2. Галсанлодой, (Уянгын хүрээний хамба). bstan-pa'i gsal-byed chen-po chos-rje no-yon bla-ma blo-bzang dkon-mchog dpal-ldan bzang-po'i rnam-thar nyid-kyi 'khrungs rabs gsol-'debs dad-pa'i sgo-'byed ltar bsgrigs-pa rnam grol thar-ba'i khang-bzang nor-bu'i bang-mdzod gus-ldan yid-'phrog ces-bya-ba bzhugs-so.[төвөд, гар бичмэл, 29.5x6.5. 52 хуудас]

3. Агваанцүлтэмжамц, *Аврал итгэлт Богд Жавзандамбын хийд Баруун хүрээний гарсан ёсыг товч өгүүлсэн шударга оршигчдын чихний чимэг хэмээх оршвой*(төвөд хэлнээс орчуулсан гавж, доктор Ш.Сонинбаяр. (1995). Улаанбаатар: “СҮНА” хамтлагт бэлтгэв.

4. Галсанлодой, *Шашныг тодруулагч их цорж ноён лам Лувсангончогбалданбалсамбуугийн намтар төрөл дарааллын залбирал Сүсгийн үүдийг нээгч хэмээхийн дагуу жигдрүүлсэн тонилгох нирвааны сайн байшин чандманийн хүү сан Сүсэгтний сэтгэлийг булаагч* (төвөд хэлнээс орчуулсан Д.Даваасүрэн. (2000). Шашны зурхай эрдэнийн эрих хэмээх оршвой, Улаанбаатар: “Амрида” компанид бэлтгэж хэвлэв. Монгол бичгээр 215-308 талд, төвөдөөр 309-385 талд)

5. Даваасүрэн, Д. (2021). *Өндөр гэгээний Өвгөн хүрээ*. Улаанбаатар: Линограф хэвлэх үйлдвэр

6. Даваадорж, Ж.(2023). *Өндөр гэгээний их хүрээ Баруун хүрээ*. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК

Товчдоо, Өвөрхангай аймгийн Хархорин сумын Шанх багийн нутагт буй Баруун хүрээний түүх болон уг хүрээний хувилгаан лам Ноён лам нарын намтарт холбогдох төвөд эх сурвалж өвлөгдөж бидний үед ирсэн. Түүнийг гавж, доктор Ш.Сонинбаяр тэргүүтэй судлаачид тухайлан судалж, монгол хэлнээ орчуулан олны хүртээл болгосон.

Мөн хэдийгээр 1937 оноос өмнөх Баруун хүрээнд шавилж байгаагүй ч, 1990 онд дахин сэргэсэн тус хүрээнд шавилж, тухайн үед энх тунх байсан гэргэн лам нараас хүрээний түүхэнд холбогдох аман яриа дуулж сонссон, түүнийгээ төвөд эх сурвалжийн мэдээгээр тулган нягталсан судлаачид байна. Ийм байсаар байтал, Баруун хүрээний байгуулагдсан ёс, газар оронд холбоотой өдгөө хүртэл яригдсаар байдаг буруу ташаа мэдээлэл дээрх цувралуудад орсон, мөн “Цуврал II”-ын удиртгалд “...энэ ном тун удахгүй англи хэлэнд орчуулагдана” (Майер Жужа ба Телеки Кристина, 2023:6) гэх мэдээнд тус тус үндэслэн, номыг сөхөхийн зуур хэдэн үг яаран эвлүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Нэгэн зүйл. Бичлэгээс буулгахдаа ташаарсан байгаасай...

Хишигтийн Гомбо нь Номгоны Дара эх ламтны сүмийн шавь бөгөөд тус сүм нь Баруун хүрээний Ноён ламын сүм Пунцагдаржаалинтай одоогийнхоор бол хөршийн холбоотой, лам нараа солилцдог хамтын ажиллагаатай байжээ. Эндээс Х.Гомбо нь өөрийгөө Баруун хүрээний Ноён ламын сүм Пунцагдаржаалингийн шавь гэж үзэх боломжтой. Гэвч, түүний “1988 онд дахиж лам болоод 1998 он хүртэл Шанхын хүрээнд сууж байсан” (Телеки Кристина, 2023:55) гэсэн нь ташаа мэдээлэл юм. Үүнийг нотлохын тулд дараах хоёр баримтыг эш татаж байна. Үүнд:

1. Гэрэл зураг
2. Албан бичиг

“Өндөр гэгээний Өвгөн хүрээ” номын 105 дахь талд буй 1990 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Баруун хүрээ дахин сэргэх өдөр авсан гэрэл зураг байна. Уг зургийг тухайн үйл явдлыг хөндлөнгөөс ажигласан гадаадын гэрэл зурагчин авч, хожим тус хүрээнд шуудангаар илгээсэн байна. Зураг дээр Гандантэгчэнлин хийдийн цорж лам Осор тэргүүтэй тус хүрээний шавь болох лам нар Улаанбаатар хотоос очиж, нутагтаа байсан бусад лам нарын хамт Шанх багийн төвд барьсан гэр дуганд хурал хурж байна (Зураг 1 үз).




Зураг 1. Хурал нээгдэх үе.

Арын эгнээний дээд талаас: Ноён ламын Пунцагдаржаалин сүмийн унаган шавь, Гандантэгчэнлин хийдийн цорж, гэлэн Осор, Баруун хүрээний унаган шавь унзад Луузанням, дахин сэргэсэн Баруун хүрээний их унзад Л.Нацаг, гэлэн Шарав, гэсгүй Дашдондог, Гандантэгчэнлин хийдийн гэсгүй Лхагвасүрэн.

Урд эгнээний дээд талаас: Баруун хүрээний унаган шавь Г.Найдан, Осор нар.

Эдүгээ Шанхын Баруун хүрээний архивт хадгалагдаж буй дараах албан бичгийг 1990 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Номгон уулын Пунцагдаржаалин хийдээс тус хүрээнд илгээсэн бөгөөд тус албан бичгийн доор нь ловон Д.Содном, даа лам Х.Гомбо хэмээсэн байна (Зураг 2 үз).



Зураг 2. Номгон уулын Пунцагдаржаалин хийдээс Баруун хүрээнд илгээсэн бичиг

Дээрх хурал хурах “Өргөө дуганы тухай” бичигт *“Их дээдэс Далай ламтны зарлигт Пунцагдаржаалин хийдийн хурах хурах өргөө дуганаар гачигдаад хурлаа хурж амжихгүй саатаад байгааг болгоож 6 ханатай өргөө дуганаа зохих үнээр хайрлаж туслахыг гүнээ хүсье. ЖИЧ: Зуугийн ловон Дэндэвийн амнаас Зууд авахгүйг надад хэлсэн юм шүү. Одоо урьдчилгаа болгож 1000 төгрөгөө тушааж дараа авахдаа 6000 төгрөгөө бэлэн өргөө дуганаа авч хурлаа хурах болно”* хэмээн гараар бичжээ.

Дээрх баримтууд болон 1990 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр дахин сэргэсэн Баруун хүрээний архивын бичиг баримт, мөн лавтай 1998 онд Х.Гомбо нь Улаанбаатар хотод буй Ламрим дацангийн ловон ламын албатай байсныг мөн уг дацангийн архивын бичиг баримтаас шүүн үзвэл, эрхбиш үнэн нь тогтоогдоно гэдэгт итгэлтэй байна.

Миний бие Х.Гомбо гуайг нэгэн өвөл (1991, 1992 оны алиныг нь тодорхой санахгүй байна) Баруун хүрээнд ирж, “Ламрим” болон “Найман богдын дончид” хурж байсныг гэрчлэх бөгөөд 1998 он хүртэл Баруун хүрээнд шавилан сууж байгаагүй болно.

Тиймээс энэхүү цувралыг эрхлэгчид Номгоны Дара эх ламтны сүмийн шавь, хожмын Ламрим дацангийн ловон Х.Гомботой ярилцлага хийснээс хойш даруй 14 жилийн зуурт зарим мэдээг нягтлан, нэмэлт тайлбар дагалдуулах боломжтой байв.

Нэгэн зүйл. Баруун хүрээг “Шанх уулын өвөр Сайхан булгийн дэнж дээр анхдугаар Өндөр богд” байгуулаагүй.

Ламрим дацангийн ловон Х.Гомбо 2006 оны 3 дугаар сард өгсөн ярилцлагадаа *“Шанх уулын өвөр Сайхан булгийн дэнж дээр анхдугаар Өндөр Богд өөрөө оройлон байгуулсан. Өндөр гэгээн Занабазар”* (Майер Жужа ба Телеки Кристина, 2023:57) гэсэн нь түүхийн үнэнтэй таарахгүй байна. Өндөр гэгээн арван гурван нас сүүдэр зэрэгцсэн, XI жарны хорин нэг дэх “Бүхнийг номхотгогч” хэмээх улаагчин гахай жил (1647 он) номын их хийд Баруун хүрээг байгуулсныг түүхэн сурвалжид *“Арван гуравныхаа гал гахай жил их хийд Баруун хүрээ үүнийг эхлэн байгуулж хайрласан”* (Хулан, Ч ба Сю Бөрн, 2023:13) гэх энэхүү түүхэн үйл явдал нь Өндөр гэгээнийг анх хувилгааны ширээнд залсан, Ширээт цагаан нуурт өрнөсөн бөгөөд Монгол газар дэлгэрсэн Бурханы шашны гурав дахь удаагийн өлгий нутаг тэр болжээ (Даваасүрэн, 2021:42). Өдгөө байгаа бууриндаа “Тэнгэр тэтгэгч хааны тавин хоёрдугаар он, IV Богдын арван гурван насны “машид хүсэгч” хэмээх гал хонин жил (1787 он) ирж суурьшсан нь тодорхой боловч, Ширээт цагаан нуураас анх хаашаа хөдөлж, хаана хаана бууж сууж явсаар одоогийн Сайхан булгийн дэнж гэдэг газарт хүрч ирсэн нь өдгөө тодорхой бус болжээ (Даваасүрэн, 2021:43). Иймд *“дөрөвдүгээр Богдын арван гурван насны машид хүсэгч хэмээх гал хонин жилд Сайхан булгийн дэнж гэдэг газар суурьшиж оришин тогтножээ”* (Хулан, Ч ба Сю Бөрн, 2023:25) гэх мэт өмнөх судалгааны үр дүнтэй харгуулах, харьцуулах боломж байсан байна.

Бидний таамаглаж байгаагаар, Өндөр гэгээн Занабазар 13 нас сүүдэртэйдээ анх шавыг нь тавьж, хожим IV богд Лувсантүвданванчүгжигмэджамцын 13 нас

сүүдэртэй байх үед Сайхан булгийн дэнжид суурьшуулсан гэх хоёр түүхэн үйл явдал амнаас аманд дамжихдаа он цагийн ялгаагүй болж, хожмын хүмүүс ташаа ойлгоход хүрчээ гэж үзэж болмоор шиг байна.

Бас “Дурсамжид үлдсэн сүм хийдүүд” (XX зууны эхэн үеийн хүрээ хийдүүдийн тухай ярилцлагууд) цувралын 742-746 дахь талд буй Баруун хүрээний унаган шавь, дахин сэргэсэн Баруун хүрээний нярав, Да ламын алба хашиж асан Н.Дашцэрэнгийн *“Шанхын баруун хүрээг 1647 онд өндөр гэгээн Занабазар 13 сүүдэртэйдээ анх үндэслэн байгуулсан. Баруун хүрээ бол бүр анх Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутаг Ширээт цагаан нуур гэдэг газар гэр дуганаа барьж Цогчин айлдаж эхэлсэн гэдэг”* (Даваасүрэн, 2021:742) гэх мэдээтэй харгуулж үзээд, улмаар нягталж, зохих нэмэлт тайлбар, хөлийн зүүлтээр ч юм уу Х.Гомбын ярилцлага дахь мэдээ нь уг цуврал дахь бусад холбогдох мэдээгээр үгүйсгэгдэж байна. Энэ нөхцөлд хэн нэгэн нь эндүүрсэн байж болзошгүйг судлаач-эмхэтгэгчийн хувьд нягталж, эндүүрсэн нь нотлогдсон тохиолдолд тайлбар дагалдуулах шаардлагатай байсан гэж бид үзэж байна.

Бас Х.Гомбын ярилцлагад үнэн эсэхийг батлах боломжгүй, магадгүй хэтрүүлсэн байж болзошгүй “360 гавж”, “150 аграмба”, *“Өндөр гэгээнээс хойш дараагийн Богдууд дацангуудыг байгуулсан. Хамгийн түрүүнд Дүйнхор дацанг байгуулсан болов уу гэж би боддог”* (Даваасүрэн, 2021:738); Баримтын алдаатай *“Ноён лам Лувсанцэвээн”* (Телеки Кристина, 2023:58), илт худлаа гэж үзэх бүрэн үндэстэй *“анх тэр Батцагааны дуганд орж Чогчинд хурж, тэгээд улмаар Чогчин гэдэг хурал хураад, Цогчин унзад хийгээд”* (Телеки Кристина: 2023:59), *“Ноён ламын Пунцогдаржаалин хийдийг бас мөн 250-иад ламтай, тэр нь хурал ямар билээ тэр, дацан тэр хурал байхгүй”* (Телеки Кристина, 2023:61) зэрэг мэдээ мэдээлэл оржээ.

Түүхэн сурвалжийн мэдээгээр бол *“...арван дөрөвдүгээр жарны эхний гал туулай жил Жүд дацан”* (Хулан, Ч ба Сю Бөрн, 2023:25), *“тавдугаар Богдын арван настай байх арван дөрөвдүгээр жарны модон бичин жил, ...Баруун хүрээ Ноён лам Лувсанбалдангийн зохиол үйлсээр Цанид дацанг..., ... түүнээс хойш арав дахь он усан могой жил Манба дацанг”* (Хулан, Ч ба Сю Бөрн, 2023:25), *“...энэ богд Живзундамбын арван долоон насны арван тавдугаар жарны модон тахиа жилд Дүйнхор дацанг байгуулсан”* (Хулан, Ч ба Сю Бөрн, 2023:26) байдаг. Бас *“Анхдугаар дүрийн Ноён лам Пунцагравдан хорин дөрвөн нас сүүдэр зооглосон улаан луу (1736) жил Баруун хүрээний шашны эзнээр өргөмжлөгдөж, Баруун хүрээний дөрвөн аймгийн нэгэн Гандандаржаалинг шинээр байгуулсан гэдэг”* (Даваасүрэн, 2021:43).

Төвдөч эрдэмтэн Л.Хүрэлбаатар нэгэнтээ жинхэнэ эх сурвалжийг нээж үзэлгүйгээр алдаанаас алдаа хүүлж байгааг буруушаан, үүнээс сэргийлэхийг бидэнд сануулж байж билээ. *“Үг дайвал илүүддэг, мөнгө дайвал дутдаг”* гэгчээр аман хууч гуйвж түүхэн үнэнээс төөрөх нь байдаг санж. Амнаас ам дамжин яригдаж буй бол нэг хэрэг. Гэвч үүнийг баримтжуулан, судлаачийн зүгээс ямар нэг нэмэлт тайлбаргүйгээр хэвлүүлж олны хүртээл болгох, нэн ялангуяа олон улсын хэлнээ орчуулан судалгаа шинжилгээний эргэлтэд оруулах нь зохисгүй, заавал нэмэлт тайлбар хийх шаардлагатай гэж бид үзэж байгаа юм.

Баруун хүрээ судлалд холбогдох судалгаанд шууд холбоотой, өнөө хэр нь элдвээр яригддаг эмхлэх цэгцлэх шаардлагатай энэ мэт аман мэдээг хянан магадлалгүйгээр эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах нь хортой юм. Манай улсын эрдэм шинжилгээний байгууллага, судлаачдын дунд түгээмэл байдаг “*Шинжлэх ухааны докторын хэлсэн үнэн*”, эсхүл “*гаднын эрдэмтэн хэлсэн бол үнэн*” хэмээн итгэдэг, судалгааны дараа дараагийн бүтээлдээ эшлэхийг чухалчилдаг хандлагаас үзвэл, энэ мэт алдаа цааш цаашид хүүлэгдэж, нэг хэсэгтээ л төөрөгдөл бий болгох, магадгүй түүнийг засах нь молхи судлаач миний нэгэн насандаа хийж дуусахгүй их ажил ч болохыг үгүйсгэх аргагүй.

Мөн аман ярианд байдаг “*Өндөр гэгээний долоон орон*” гэдгийг баримтаар хянан үзвэл, Өндөр гэгээн Занабазар байгуулсан гэдэг талаасаа батлагддаггүй. Энэ яриаг Х.Гомбо (Даваасүрэн, 2021:736; Майер Жужа ба Телеки Кристина, 2023:65), Ж.Довдон (Майер Жужа ба Телеки Кристина, 2023:156-157) нар ярьсан байна. Ийм аман яриа дээрх нутагт байдаг. Энэ нь нутаг болгонд л нэгэн Шижир гэгч баатар байсан гэдэг шиг өөрийн нутгаа алдаршуулах гэснээс ч юм уу үүдэлтэй, амнаас ам дамжсаар үнэн мэт болсон яриатай огт ялгаагүй юм.

Тиймээс дээрх мэт баримтын алдааг англи хэвлэлд хянан нягталсны дараа, заримд нь тайлбарыг нэмэлтээр юм уу, зүүлтээр хийж байж оруулаасай хэмээн зөвлөж байна.

Нэгэн зүйл. Арга зүйгээс үүдэн...

Судалгааны арга зүйн хувьд ярилцлагын арга голчлон ашиглаж, I, II дахь цувралд нийтдээ 74 ламын, 75 хийд орны тухай, 130 шахам удаагийн ярилцлага орсон байна. Энэ нь цаг хугацааны талаас авч үзвэл 11 жилийн хөдөлмөр юм.

Оролцогчид нь бага залуудаа хийд оронд шавилж байсан, цагийн эрхээр шар шувталсан, шувтлаагүй өвгөн лам нар, ярилцлагад буй мэдээ мэдээлэл нь оролцогчийн хувийн санаа бодол, үнэлэлт дүгнэлтэд үндэслэсэн байж болдог хэдий ч, эдгээр цувралын хувьд илүү их баримтад түшиглэх шаардлагатай, магадгүй ярилцлага дахь баримттай тулгах боломжтой, шаардлагатай гэж үзсэн зарим мэдээ мэдээллийг тулгах, ярилцлагын үед оролцогч тодорхой болон тодорхой бус хүчин зүйлийн улмаас эндүү ташаа ярих, хольж хутгах тохиолдолд залах жолоодох, сануулах зэргээр судлаачаас ярилцлагын үед шаарддаг зарим мэдлэг, ур чадварыг ашиглах зэргээр тухайн үед болон дараа нь дахин ажиллах шаардлагатай байжээ гэж бид үзэж байна.

Эрдэм шинжилгээний ажлын хувьд бичвэрийн, судалгааны төлөвлөгөө гаргадаг. Ярилцлагад ч мөн ижил. Энэ нь олон талын ач холбогдолтой, хүрэх үр дүнгээ тодорхойлоход чухал алхам юм. Эхний, явцын, эцсийн гэх мэтээр үр дүнг авч үзвэл, эхний үр дүн бол нийт оролцогчдоосоо төлөвлөгөөний дагуу ярилцлага авснаар хэмжигдэж болно. Харин явцын үр дүн бол баримтыг шалгана, ямар нэг нэмэлт тайлбар хийх шаардлагатай бол хийнэ, тодруулах шаардлагатай бол тодруулна гэх мэт боловсруулалтын шатанд байж болно. Эцсийн үр дүнгийн хувьд судлаач өмнөө тавьсан хувийн зорилгодоо хүрснээр, бас ярилцлагаар илрүүлж буй нийгмийн аливаа үзэгдлийн мөн чанар, хэв шинж, ач холбогдол, түүхэн үнэнийг баримтжуулж буйгаар хэмжигдэж болно.

Ер нь ганцаарчилсан, бүлгийн болон гол бүлгийн аль ч ангилалд багтах, ямар ч ярилцлагын үр дүнг боловсруулах шатанд чанарын үнэлгээг голчлон анхаарч, юуг-яаж-яагаад гэсэн асуултад системтэйгээр хариулт өгөхийг судлаачид зөвлөсөн байдаг.

Тэгэхээр, бидний үзэхээр дээрх гурван цувралд ярилцлага өгч оролцсон өвгөн лам нарын яриан дахь мэдээ мэдээллийг боловсруулах, судалгааны өргөн хүрээний ач холбогдол, үр дүн болох түүхэн үнэнийг баримтжуулах талаасаа явцын болон эцсийн үр дүнд хүрэх шатандаа судлаачид анхаарах хэрэгтэй байжээ гэж бид үзэж байна.

Нэгэн зүйл. Ном гэдэг хэрэгтэй, түүнийг бүтээх гэдэг гавьяатай үйл

Миний бие 1990-1995 он хүртэл Баруун хүрээнд шавилж, тэнд дуганч, тахилч, бага унзад зэрэг алба хашиж байсан ч, эл гурван цувралд ярилцлага өгсөн Баруун хүрээний шавь нар болох лам нартай хамт хуралд хурж, гэр орноор нь орж гарч явахдаа хийдийн түүх, лам нарын намтартай холбоотой нэг ч болов асуулт асууж, тэмдэглэж авсан зүйл алга. Өвгөн лам нарын хоорондоо ярьж байснаас, зориудаар надад болон бидний залууст ярьж өгсөн цөөвтөр хууч ярианаас огт хэтрэхгүй. Гэвч, их завшаанаар Баруун хүрээний түүх төвөд, гар бичмэлээр бидэнд өвлөгдсөн байна. Зохиолын уг эхийг Гандантэгчэнлин хийдийн цорж, гавж гэлэн Осор хадгалж байснаа, Монголын Бурхан шашны дээд сургуулийн багш, гавж, түүхийн ухааны доктор Ш.Сонинбаяраар өгч, миний бие түүнээс цахилгаан машинаар хуулан олшруулж авсанаа өдгөө хадгалж байна.

Гэвч, дээрх гурван цувралын “Цуврал II”-т буй гэлэн Ж.Довдонгийн “Эрдэнэ зуу түрүүлж эргэвэл жаахан хүйтэрнэ гэж байсан. Баруун хүрээ түрүүлж эргэвэл дулаарна. Тэр нь ямар учиртай гэхээр Эрдэнэ зуугийн Майдар зандангаар бүтээсэн юм гэнэ лээ” (Майер Жужа ба Телеки Кристина, 2023:159), “Зулын тос гэж нэг бадар явдаг байсан. ...айл айлын гадна очоод л дунгаа үлээнэ. Тэгэхээр айлууд чинь ганжуурын юу ирлээ гээд айл бүрээс нэг халбага өрөм аваад саванд хийчихнэ. Тэгээд олон айл хэсэх учраас тэр нь зөндөө өрөм болно. Тэгээд авч ирээд хайлаад, зулын тос гаргаад зул өргөж байсан” (Майер Жужа ба Телеки Кристина, 2023:160), “Гүрэм хэнгэрэг гэж үлээнэ. Бүрээгээрээ цагаа хийсэн газар гэж ярьдаг байсан юм гэнэ лээ. Баруун хүрээг” (Майер Жужа ба Телеки Кристина, 2023:162) гэх мэт урд өмнө огт дуулж байгаагүй сонин содон мэдээ занги буй нь Баруун хүрээний шавь бус хэн нэгэнд төдийлөн ач холбогдолгүй мэт сонсогдож болох ч, өсөж төрсөн нутаг орны минь оюун санааны хувьд дахин “төрөх” зол завшаан олгосон номын их хүрээнд холбогдох ганц ч болов аман мэдээ, хууч яриа энэ мэт замаар бидэнд үлдэж байгаа нь ихэд үнэ цэнтэй юм.

Тиймээс социализмын үеийн Монгол улсад ил болон далд хэлбэрээр оршиж, монголчуудын оюун санааны хөтчийн үүргээ гүйцэтгэсээр ирсэн Бурханы шашин, түүнийг цагийн бэрхэд амьтайгаа дүйлгэн тээж, өв соёлыг хадгалж өнөөгийн бидэнд уламжлуулсан гаднаа хөдөөх хар шиг боловч, чухам дотроо номын ёсыг чанад баримтлан, өдөр тутмын болон сарын, улирлын, жилийн дүйцэн хурлаа ч таслалгүй нууцаар хурсаар ирсэн эх орны минь өнцөг булан бүрд байсан өвгөдийн гавьяаг судлан баримтжуулахад үнэтэй хувь нэмэр оруулсан

“Монголын Бурханы шашны аман түүх” хэмээх гурван цувралын зохиогч, эмхэтгэгчид болох эрхэм судлаачдад чин сэтгэлээсээ талархаж байгаагаа эцэст нь онцлон тэмдэглэж байна.

Та бүхний цаг хугацаа, хөрөнгө мөнгө, чин сэтгэлээ зориулсан энэхүү судалгаа Монгол судлал, Монголын Бурхан шашны судлал, уламжлалт Бурханы шашны зүтгэлтнүүдийн намтар судлалд хувь нэмрээ оруулж, судлаачдын ширээний ном болсоор байх болно гэдэгт эргэлзэхгүй байна.

Ном зүй

- Телеки Кристина. (2023). *Өндөр настан лам нарын яриа (XX зууны эхэн үеийн хүрээ хийдүүдийн тухай ярилцлагууд) 2007-2017*. Улаанбаатар: Соёмбо принтинг
- Майер Жужа ба Телеки Кристина.(2023). *Өндөр настан лам нарын яриа (XX зууны эхэн үеийн хүрээ хийдүүдийн тухай ярилцлагууд) 2006-2009*. Улаанбаатар: Соёмбо принтинг
- Даваасүрэн, Д. (2021). *Өндөр гэгээний Өвгөн хүрээ*. Улаанбаатар: Линограф хэвлэлийн үйлдвэр
- Хулан, Ч ба Сю Бөрн. (2023). *Дурсамжид үлдсэн сүм хийдүүд (XX зууны эхэн үеийн хүрээ хийдүүдийн тухай ярилцлагууд)*. Улаанбаатар: Соёмбо принтинг